

№	Агуулга	Хуудас
1	Төслийн товч танилцуулга	2
2	Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	7
3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	9
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2023 оны зорилт	9
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
6	Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	16
7	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	16
8	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	17
9	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	20
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	22
11	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	24
12	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	25

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### **Төслийн хэрэгжүүлэгч:**

“МЕРА”ХХК

### **Төслийн нэр:**

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”

**Улсын бүртгэлийн дугаар:** 9011108011

**Регистрийн дугаар:** 2619687

### **Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

Монгол улс-210644, Улаанбаатар хот | Сити Тауэр /17 давхарт/, Чингис хааны нэрэмжит талбай 1, 8-р хороо Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол улс, 14200

**Утас:** 75 55 66 77 **Факс:** 11 319276 |

### **Төслийн байршил.**

Налайх дүүргийн Засаг Даргын 2008 оны 03-р сарын 12-ны өдрийн 94 тоот шийдвэрийг үндэслэн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт 000323072 нэгж талбарын дугаар бүхий 82846 м<sup>2</sup> газрыг (8.2 га) үйлдвэрлэлийн зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр гэрчилгээ олгогдсон. ҮАЦ нь Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт Улаанбаатар хотоос зүүн урагш 45км, Налайх дүүргийн төвөөс баруун урагш 2.4 км зайтай байрладаг.

### **Төслийн хэрэгжих орчмын байрзүйн солбилцол:**

#	X	Y
1	47°44.860'N	107°14.869'E
2	47°44.858'N	107°14.779'E
3	47°44.745'N	107°14.784'E
4	47°44.669'N	107°14.903'E
5	47°44.668'N	107°14.988'E
6	47°44.828'N	107°14.985'E
7	47°44.827'N	107°14.865'E

“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн шаардлагын дагуу үйлдвэр нь байнгын их хөдөлгөөнтэй зам, улсын чанартай объект, хүн ам бүхий суурингаас нэг километрийн зайтай байх, бэлэн бүтээгдэхүүн болон түүхий эдээ төмөр зам болон авто замаар тээвэрлэх боломжтой, өндөр хүчдэлийн цахилгаан шугамд холбогдох боломжоор хангагдсан байх шаардлагыг үндэслэн үйлдвэрийн байрлалыг Налайх-Чойр чиглэлийн автозамаас 950 метр, Улаанбаатар-Замын үүд чиглэлийн төмөр замаас 15 км зайд, цэргийн локаторын ангиас 930 метр алслагдсан зайд сонгон байгуулсан.



**Зураг 1.** Төслийн байршил /Google earth/



**Зураг 2.** Үйлдвэрийн харагдах байдал



## **Төслийн хүчин чадал**

Тэсрэх бодисын үйлдвэр агуулахын цогцолбор нь одоогийн байдлаар нийт 35 ажилтан, албан хаагчтай ба 4 ээлжээр ажиллаж жилд 6.0 мян. тонн савлагаатай хүчитгэсэн болон хүчитгээгүй энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай.

Тэсрэх материалын агуулахын нийт багтаамж 2008 оны байдлаар 200 тн байсан ба 2011 онд 150 тн багтаамжтай түүхий эдийн агуулахуудыг нэмж барьсан ба 2018 оны байдлаар агуулахын ерөнхий багтаамж 1200 тн болсон.

### ***Химийн бодисын хэрэглээ.***

Тэсрэх бодисын үйлдвэрийн технологит доорх нэр төрлийн химийн бодисуудыг ашигладаг ба 1 төрлийн бэлэн бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирж компани өөрийн үйл ажиллагаанд хэрэглэн тэсэлгээний ажил үйлчилгээ гүйцэтгэх ба зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид худалдаалах ажлыг явуулдаг. Аммоны нитрат (аммиакийн шүү), дизелийн түлш, хөнгөн цагааны нунтаг зэрэг химийн бодисыг үйлдвэрийн технологийн үйлдвэрлэл буюу бүтээгдэхүүний найрлагын түүхий эд байдлаар ашигладаг.

### ***Энгийн тэсрэх бодисын үйлдвэр***

Улаанбаатар хотын Налайх дүүрэгт 2006 онд энгийн тэсрэх бодисын үйлдвэрийг ашиглалтад оруулснаар Монгол улсад үндэсний хөрөнгө оруулалттай анхны тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор байгуулагдсан. Уг үйлдвэрийн цогцолборт АНУ-д үйлдвэрлэсэн, энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх иж бүрэн суурин тоног төхөөрөмж, энгийн тэсрэх бодис үйлдвэрлэн цооногт цэнэглэгч автомашинууд, бүтээгдэхүүний чанарт хяналт хийх зориулалт бүхий лаборатори, туршилтын полигон багтаж байгаа бөгөөд бүтээгдэхүүний орц найрлагыг хянах, тоо хэмжээ тоолох удирдлагын автомат системээр тоноглогдсон орчин үеийн үйлдвэр юм. Үйлдвэр нь энгийн тэсрэх бодисыг тухайн газрын чулуулгийн хатуулаг, орчны шинж чанарт тохируулан Энгийн буюу "Аянга", Хүчитгэсэн буюу "Аянга-Х", Усанд тэсвэртэй буюу "Аянга-УТ" гэсэн 3 төрлөөр үйлдвэрлэж, полиэтилен дотортой, полипропилен гадартай давхар уутанд 25 кг-аар шуудайлан, мөн 76мм, 101мм, 127мм-ийн голчтой олгойлон савлаж байна.



**Зураг-3. Энгийн тэсрэх бодисын үйлдвэрлэлт**

### ***Өдөөгчийн үйлдвэр***

Монгол Улсын уул уурхай, зам, барилгын салбарын тэсэлгээний ажилд 100% импортлон ашиглаж буй өдөөгчийг үйлдвэрлэнэ. Энэхүү өдөөгч нь сул мэдрэх чадвартай тэсрэх бодис болон тэсэлгээний үндсэн цэнэгийг өдөөж тэслэх зориулалттай. Уул уурхай, зам, барилгын тэсэлгээнд хэрэглэх зорилгоор төрөл бүрийн хэмжээгээр үйлдвэрлэдэг бөгөөд жилд 500 тонн өдөөгч үйлдвэрлэх хүчин чадалтай.



**Зураг-4. Өдөөгчийн үйлдвэр**

### ***Тэсэлгээний хэрэгсэл угсрах үйлдвэр***

Уул уурхайн салбарт чанартай, хямд, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, компанийн үйлдвэрлэлийн салбарыг нэмэгдүүлэх зорилгоор АНУ-ийн Аустин детенатор компанийн жилд 500,000 ширхэг цахилгаан бус хэрэгсэл угсрах хүчин чадал бүхий үйлдвэр юм.



**Зураг-5. Хэрэгсэл угсрах үйлдвэр**

### ***Агуулахууд***

Үйлдвэрийн агуулахууд нь түүхий эд, туслах материалын, импортын эмульсийн тэсрэх бодисын, тэсэлгээний хэрэгслийн, бүтээгдэхүүний (ANFO) гэж ангилагдах бөгөөд агуулахын хамгийн их багтаамж нь (аммиакийн шүү орохгүйгээр)-1200 тн, үүнээс ЭТБ-100 тн, Эмульсийн тэсрэх бодис-1100 тн, аммиакийн шүү-1500 тн, бусад тэсэлгээний хэрэгсэл хадгалах хүчин чадалтай.

Налайхын тэсрэх бодис, түүхий эд материалын агуулахуудыг ТААНД-ийн шаардлагын дагуу тоногдсон бөгөөд эдэлбэрийн зүүн хэсгийг шороон далангаар тусгаарлан, аянга зайлуулагчаар аянгаас хамгаалсан дөрөв дөрвөөр нь зэрэгцүүлэн барьсан агуулахуудад хадгалдаг.





**Зураг-6. Тэсрэх материал, түүхий эдийн агуулах**

### *Захиргаа аж ахуйн барилга*

Үйлдвэрийн захиргаа, аж ахуйн хэсэг үйлдвэрийн хойд хэсэгт байрладаг давхар барилгын баруун жигүүрт байрладаг ба өнгөрсөн хугацаанд барилга дотор явуулж буй үйл ажиллагаанд өөрчлөлт оруулаагүй. 2020 онд орон тоо нэмэгдэж буйтай холбоотой оффисын барилгад өргөтгөл хийж, ажиллах нөхцөл, орчинг сайжруулахаар төлөвлөн, ажлын зураг хийлгэж бэлэн болсон.

Энэхүү барилгад тус (албан контор, ажилчдын цайны газар, ажилчдын 1 ээлжийн душ, хувцас угаалгын хэсэг, халаалтын блок, хувцас солих өрөө гэх мэт өрөө тасалгаануудтай), лабораторийн хэсэг бүхэлдээ байршина. 2020 онд лабораторыг өөр газар шинээр бариж байгуулахаар төлөвлөж барилгын ажлыг эхлүүлсэн.

Мөн үйлдвэрийн байр, бэлэн бүтээгдэхүүний болон түүхий эдийн агуулах, оффисын барилга зэрэг шаардлагатай газруудад 44 ширхэг хяналтын камер байрлуулан интернетийн сүлжээтэй байрлалаас 24 цагийн турш хянаж байна.



**Зураг 7. Захиргаа, аж ахуйн барилгын харагдах байдал**

## Үйлдвэрийн лаборатори

Үйлдвэрийн түүхий эд бүтээгдэхүүний чанарын хяналтыг үйлдвэрийн лабораториор хянаж ажилладаг ба үйлдвэрийн гадна талбайд зөвшөөрөгдсөн зайд тусгайлан тоноглож байгуулсан туршилтын талбайд бүтээгдэхүүний туршилтын ажлыг мэргэжлийн эрх бүхий үнэмлэхтэй тэсэлгээчид гүйцэтгэдэг.



**Зураг 8. Үйлдвэрийн хяналтын лаборатори**

### Хүснэгт 1. Лабораторид гүйцэтгэж байгаа сорилтууд

Сорилт хийх материалын нэр	Гүйцэтгэж байгаа сорилтын төрөл
Аммонийн нитратын механик сорилт	Шингээх чадвар
Дизель түлшний үзүүлэлтүүд	Хүлээн авах үеийн хяналт
“Аянга” бүтээгдэхүүний түүхий эд	Орц найрлага
Тэсрэх бодисын өдөөгч	Өдөөлтийн эрчим, хүч



**Зураг 9. Тусгайлан тоногдсон туршилтын талбай**

## **ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

### ***Физик газарзүй:***

Налайх дүүрэг нь газарзүйн байршлын хувьд Хэнтийн уулархаг мужид хамаарагдана. Геоморфологийн хувьд голын татмын дэвсгэр нутаг болох бөгөөд голын татмаар нэвчилт шүүрэлт ихтэй сийрэгдүү, элс сайр, сайрган, хайргархаг аллювийн хурдас зонхилно.

### ***Цаг уур, уур амьсгал:***

Уур амьсгалын үндсэн нөхцөл нь эх газрын эрс тэс цаг агаарын шинжтэй, хот орчмын бичил, бэсрэг уур амьсгалын онцлогтой. Налайх орчмын агаарын температур өвөл 18.80 - 22.70, зун 12.80 - 15.40, Жилд унах тунадасны хэмжээ 260-290 мм, жилийн дундаж агаарын даралт 852.3 гПа, дундаж салхины хурд жилд 4.2 м/с байна.

### ***Гадаргын болон газар доорхи ус:***

Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор орчимд гадаргын ус байхгүй. Налайх орчмын гидрогеологийн зурагт тэмдэглэснээр Налайхын нүүрсний уурхай орчимд Туул голын хөндийд газрын доорхи устай аллювийн хурдас, Налайхын хотгорт их талбайд тархалттай, бага нөөцтэй газрын доорхи устай доод цэрдийн хурдас, үндсэндээ усгүй неогений хурдас тус тус тархсан байна.

### ***Хөрс, ургамал, амьтан:***

Хөрс газарзүйн мужлалаар уулын хар хүрэн, хар шороон, уулын тайгын ширэгт, уулын ойн бараан хөрстэй Хэнтийн өмнөт тойрогт багтдаг. Үйлдвэр байрлаж буй газрын хэмжээнд хээрийн хөнгөн шавранцар хар хүрэн хөрс зонхилон тархана.

Ургамалжилтын ангиллаар Бага Хэнтийн уулархаг мужийн уулын хээр, нам толгодын хөндий, тал хээрийн бүсэд багтана. Налайхаас зүүн урагш Баянгийн овоо, Баян-Уул хүртэл уулын хээрийн хөнгөн шавранцар хөнгөн хөрстэй, жижиг үетэн-алаг өвст, чулуурхаг нам толгодоор үетэн-алаг өвст-үетэн-агьт бүлгэмдэл тааралдана. Налайх суурингийн орчим Хонхор нуур хүртэл нам толгодын бэл хөндийгөөр үетэн-агьт, үетэн-алаг өвс-шарилжит, үетэн шарилжит бүлгэмдэлтэй талхлагдсан бэлчээр зонхилно.

Амьтны аймгийн мужлалаар Хэнтийн тойрогт багтана. Налайх дүүрэг орчимд цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад багтана.

### ***Нийгэм-эдийн засаг,***

Налайх дүүрэг нь Засаг захиргааны 7 хороотой. 5 болон 6 дугаар хороод нь жуулчдыг татдаг байгалийн үзэсгэлэнт газар болох Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт байрладаг.

Монгол Улсын авто замын босоо болон хэвтээ тэнхлэгийн огтлолцолд оршдог, авто зам, төмөр зам, агаарын тээвэр хөгжсөн, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй,



нийслэлийг цэвэр усаар хангаж байгаа дээд эх үүсвэртэй шууд холбогдсон, Монгол орны аялал жуулчлалын гол бүс нутаг хамаардаг, хүн амын дийлэнх олонхийг залуучууд болон хөдөлмөрийн насныхан эзэлдэг, түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт ихтэй зэрэг давуу тал олон.

## **ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

Түүхий эд болон бэлэн болсон бүтээгдэхүүнийг ачиж буулгах, тээвэрлэх явцад хөрс элэгдэх, эвдрэх, агаарт тоос дэгдэх, хог хаягдал, түүхий эдийг ил задгай хаяснаас хөрсний бохирдол үүсэх, автомашины хөдөлгөөнөөс үүдэн зам орчмын ургамлан бүрхэвчид нарийн ширхэгт тоос тогтож улмаар ургалтад нь сөргөөр нөлөөлөх зэргээр үйлдвэр агуулахын цогцолбор төслөөс байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх боломжтой байдаг.

### **ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ЗОРИЛТ**

“МЕРА” ХХК нь энгийн тэсрэх бодис, задгай болон савласан эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн бага түвшинд байлгахыг 2023 онд зорилт болгон ажиллаж байна.

- Монгол улсын Үндсэн хууль болон бусад байгаль орчинтой холбоотой хууль, дүрэм журам, стандартуудын хүрээнд үйл ажиллагаа явуулах.
- Байгалийн нөөц баялгийг ариг гамтай ашиглаж, үйл ажиллагаанаас бий болсон хоёрдогч түүхий эд, материалыг зүй зохистой ашиглах ба дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
- Сум орон нутгийн байгууллагатай байгаль орчин нийгмийн хүрээнд хамтран ажиллаж, төслийн үйл ажиллагааг нээлттэй байлгах.
- “Байгаль орчны менежментийн тогтолцоо, шаардлага, хэрэглэх арга зүйн заавар MNS ISO 14001:2016” стандартын хэрэгжилтийн нийцтэй байдлын талаарх магадлах гадаад аудитыг хийлгэж, байгальд сөрөг нөлөөлөл багатай техник, технологиор үйл ажиллагаагаа явуулж, учирч болзошгүй эрсдэлүүдийг байнгын хяналтандаа байлгах.
- Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний сайжруулалтыг хийж, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг тодорхойлох.
- Үйл ажиллагааны процессуудын эрсдэлийн тодорхойлж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах.

**ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
<b>АГААР ОРЧИН</b>									
1	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмаас ялгарах хорт утаа агаар орчинд нөлөөлөх	Бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээ хийх	Төслийн хэмжээнд	-	Дотоод хяналтаар	-	Дотоод хяналтаар	Тогтмол	Агаарын тухай хууль
2	Ажлын байр, ажилчдын амрах байрт агаарын чанар муудаж хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй	Төсөл орчмоос гарч байгаа дуу чимээг стандартын түвшинд байлгах, давсан тохиолдолд эх үүсвэрийг тодорхойлж, багасгах арга хэмжээ авах.	Төслийн хэмжээнд	-	Дотоод зардлаар	-	Дотоод зардлаар	Тогтмол	MNS 4885:2007, Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөгдөх дээд хэмжээ, ажилтны сонголт хамгаалахад тавих ерөнхий шаардлага MNS6768-2019
3	Дотоод болон гадаад орчны агаарын бохирдол	T14 үйлдвэрийн ажиллах орчны агаарын чанарын урсгалыг сайжруулах	Төслийн барилга байгууламж	-	Дотоод хяналтаар	-	Дотоод хяналтаар	Байнгын үйл ажиллагаанд	MNS 5010-2001 Тоос. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага

4		Агаарын чанарыг тогтмол шалгах	Үйлдвэрийн гадна	Ширхэг	₮ 40,000.00	3 байршил	₮ 120,000.00	2023 онд	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
5		Үйлдвэрийн байрны дотоод орчны агаарын чанарыг хэмжих багаж суурьлуулах	Үйлдвэрийн байр дотор /хяналтын өрөөнд-1, химийн бодис буулгах хэсэгт-1, үйлдвэрийн хэсэг дотор-1/	Ширхэг	₮ 500,000.00	3 ширхэг	₮ 1,500,000.00	2023 онд	MNS 5885:2008 Агаарын бохирдуулагч бодисын хүлцэх хэм хэмжээг Арга, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
6	Бодис уурших, исэлдэн ангижрах урвалд орох, салхины нөлөөгөөр тархах зэргээр агаарын чанарыг өөрчлөх	Тэсэлгээний бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд, зориулалтын сав баглаа боодол, контейнерт хадгалах.	Төслийн хэмжээнд	-	Дотоод төлөвлөлтөөр	-	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, “Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага” MNS4992-2000
<b>Нийт зардал</b>							₮ 1,620,000.00		



**ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

1	Тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор зам засвар аричилгаа, усалгаа хийх	Төслийн хэмжээнд	Литр	₮ 180,000.00	Жилд 2 удаа	₮ 360,000.00	Хуурайшилтай үед	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ 5850-2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2		Хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх. Тээврийн хэрэгслүүдэд байрлуулсан GPS-ийн мэдээнд хяналт тавих	Төслийн хэмжээнд	-	Дотоод зардлаар	-	Дотоод зардлаар	Тогтмол	
3	Ахуйн хог хаягдал алдагдаж хөрс бохирдуулах	Хог хаягдлын менежмент төлөвлөгөө боловсруулж мөрдөж ажиллах	Мера ХХК	-	Дотоод зардлаар	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан	Тогтмол үзлэг шалгалт хийх	Хог хаягдлын тухай хууль, бусад холбогдох журам, стандартын хүрээнд Хог хаягдлын тухай хууль, бусад холбогдох журам, стандартын хүрээнд
4		Хог хаягдлын сав, цэгийн тохижилт, засвар үйлчилгээг тогтмол хийх	Төслийн хэмжээнд	-	₮ 350,000.00	Улирал тутам	₮ 1,400,000.00	Улирал тутам	
5		Бүх төрлийн химийн бодис, шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл,	Төслийн хэмжээнд	-	Дотоод зардлаар	Төсөл хэрэгжих хугацаанд	Дотоод зардлаар	Тогтмол	

	Тэсэлгээний бодис тээвэрлэх, түгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаа шаардлагын дагуу зөв явагдаагүйгээс тэсэлгээний бодис хөрсөнд алдагдаж, хөрс бохирдуулах	системээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд хадгалах							“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 54/А/136/А/125 дугаар хамтарсан тушаал Хөрс хамгаалал, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
6		Тэсэлгээний бодис, материал хүлээн авах талбай, агуулах, үйлдвэрийн барилга байгууламж, шал зэрэгт байнгын үзлэг шалгалт хийж, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд дор нь засварлах.	Төслийн барилга байгууламж	-	Дотоод зардлаар	-	Дотоод зардлаар	Тогтмол	
7	Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн доройтол	Хөрсний мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар жилд 1-2 удаа хийлгэж, үр дагаврыг тогтмол хянах	Үйлдвэрийн талбайд	Ширхэг	₮ 40,000.00	4 байршил	₮ 160,000.00	Жилд 1-2 удаа	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2018
	<b>Нийт зардал</b>						<b>₮ 1,920,000.00</b>		

**УСАН ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

1	Бараа материалын тээвэр хийх хүнд машин механизмын хөдөлгөөнөөр үүссэн бохирдол болон хог хаягдал нь үерийн усаар зөөгдөх	Ахуйн хуурай хог хаягдалын цэг болон шингэн хаягдлыг зайлуулах цэг, машин техникийн зогсоол зэргийг жалга, суваг шуудуунаас хол зайд байрлуулах	Төслийн талбайд	-	Үйл ажиллагааны зардалаар	-	Үйл ажиллагааны зардалаар	Тогтмол	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2	Тэсэлгээний хорт болон аюултай бодисыг үйл ажиллагаандаа хэрэглэх явцад шаардлагын дагуу хэрэглээгүйгээс бодис алдагдаж усны нөөцийг бохирдуулах	Төслөл, үйлдвэр болон агуулах орчмын үерийн хамгаалалт, даланд үзлэг шалгалт хийж, засварлаж байх	Төслийн хэмжээнд	-	₮ 200,000.00	Улирал бүр	₮ 800,000.00	Тогтмол	Усны тухай хууль, MNS3342-82 Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага Холбогдох хууль тогтоомжын хүрээнд
3	Үйлдвэр, ахуйн бохир ус алдагдаж, гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах	Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжид тушаах	Үйлдвэрийн оффис	тн	10000	Хэрэглээгээр	₮ 3,060,000.00	Тогтмол	
<b>Нийт зардал</b>							<b>₮ 3,860,000.00</b>		



УРГАМЛАН НӨМРӨГ									
1	Үйлдвэрийн болон орчны талбай дахь хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх	Ургамлын мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, үр дагаврыг тогтмол хянах	Төслийн талбай болон орчны бүсэд	-	₮ 40,000.00	4 байршил	₮ 160,000.00	Жилд 1-2 удаа	Ургамлын мониторинг хийх гадаад ба дотоодын судлаачдын гаргасан аргачлал арга зүйг баримтлана
2		Эдэлбэр газрын хэмжээнд талбайн тохижилтыг хийж, ногоон байгууламж байгуулах	Төслийн талбайд	-	Дотоод төлөвлөлтөөр		Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав	Байнгын үйл ажиллагаанд	
<b>Нийт зардал</b>							<b>₮ 160,000.00</b>		
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ									
1		Ажилчдыг тусгай хувцас хэрэгслээр бүрэн хангах		-	Дотоод зардлаар	-	Дотоод зардлаар	Ажилтан бүрийг тусгай хувцас хэрэгслээр хангах	-Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл ахуйн тухай хууль -Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
2	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Ажилчдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Химийн бодистой харьцаж ажилладаг бүх ажилчид	-	₮ 1,000,000.00	Химийн бодистой харьцан ажилладаг ажилчдын тоогоор	₮ 1,000,000.00	Жилд 1 удаа	

3		Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах		-	₮ 1,000,000.00	Сард 1 удаа	₮ 12,000,000.00	Сард 1 удаа	-Хамгаалах хувцас еранхий шаардлага
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчинг хамгаалах, гал түймэр, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах	Салбарын бүх ажилчид	-	₮ 1,000,000.00	Жилд 1 удаа	₮ 1,000,000.00	Жилд 1 удаа	-Хөдөлмөрийн тухай хууль -Галын аюулгүй байдлын тухай хууль
5	Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	Төслийн хэмжээнд	-	-	-	-	2 жилд 1 удаа	-Галын аюулгүй байдлын тухай хууль - Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам
6		Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд дүгнэлт гаргуулах	Төслийн хэмжээнд	-	₮ 5,000,000.00	Жилд 1 удаа	₮ 5,000,000.00	Жилд 1 удаа	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийх журам
		Байгаль орчны аудит хийлгэх	Төслийн хүрээнд	-	₮ 10,000,000.00		₮ 10,000,000.00	2 жилд 1 удаа мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10-р зүйл
	<b>Нийт зардал</b>						<b>₮ 29,000,000.00</b>		

### ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
2	Төсөл хэрэгжих газрын байгаль цаг уурын онцлогт тохируулан үйлдвэрийн хашаан дотор мод тарьж ногоон байгууламжийг өргөтгөн байгуулах	Мод тарих /хайлаас, буйлс, улиас/	Эзэмшлийн газрын 10%-иас багагүй талбай буюу 0.5 га талбай  0,5 га *3000ш = 1500 ш суулгац	1 га-д тарих модны тоо хэмжээ 3000ш суулгац	₮ 6,000	1500ш	₮ 9,000,000.00	Жилд 0,5 га	Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаарлдага MNS 5918:2018 Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
<b>Нийт зардал</b>							<b>₮ 45,500,000.00</b>		

### ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Тэсрэх бодисын үйлдвэр нь газрын хэвлий ухах, ашигт малтмалын үйл ажиллагаа явуулахгүй тул түүх, соёлын өвд олдох, өртөхгүй	Төслийн талбайн хэмжээнд түүх соёлын өв олдсон тохиолдолд орон нутгийн төрийн байгууллагатай хамтран ажиллах	Төслийн хэмжээнд	-	Дотоод зардлаар	Дотоод зардлаар	2023 онд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
<b>Нийт зардал</b>						<b>₮ 0.00</b>		



## НАЙМ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
<b>БОЛЗОШГУЙ ОСОЛ</b>								
1	Хөрс, болон усан орчинд химийн болон тэсэлгээний бодис асгарч, алдагдах	Ажилтнуудыг химийн бодисын хор аюул, түүнтэй хэрхэн харьцах, асгарч, алдагдсан үед авах арга хэмжээ, хувийн хамгаалах хэрэгсэл, анхны тусламж, галын аюулын үед авах арга хэмжээний талаар сургалтанд хамруулах	Тэсрэх бодисын үйлдвэрийн ажилтнууд	Жилд 2 удаа	₮ 500,000.00	₮ 1,000,000.00	2023 онд	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011
2		Битүү болон задгай агуулахын шалыг зай завсаргүй бетондсон байх	Төслийн хэмжээнд	-	₮ 1,000,000.00	₮ 1,000,000.00	2023 онд	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014
3	Химийн бодисын битүүмж алдагдах	Химийн бодисын сав баглаа боодлыг тогтмол шалгах	Төслийн хэмжээнд	-	Дотоод хяналтаар	Дотоод хяналтаар	Шатамхай, хортой бодисын сав баглаа боодлыг өдөрт 1 удаа, бусад бодисын 7 хоногт 1 удаа шалгах	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам

4	Хортой хий хуримтлагдах	Агааржуулалтын системийн засвар үйлчилгээг тогтмол хийх	Төслийн хүрээнд	-	Дотоод хяналтаар	Дотоод хяналтаар	Үйл ажиллагааны явцад тогтмол хийх	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014
5	Техник хэрэгсэлтэй харьцах үед гарч болзошгүй осол аваар	Тоног төхөөрөмжийн операторыг химийн бодисын хор аюул, түүнтэй хэрхэн харьцах, анхны тусламж, хамгаалах хэрэгсэл, галын аюулын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон сэрээт өргөгчийг аюулгүй ажиллуулах сургалтанд хамруулах	Төслийн хэмжээнд	-	Дотоод зардлаар	Дотоод зардлаар	Тогтмол	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011
6	Санамсаргүй байдлаас химийн бодисын бүрэн бүтэн байдал алдагдаж асгарах	Химийн бодисын сав баглаа боодол битүүмжийг тогтмол шалгах	Төслийн хэмжээнд	-	-	-	Өдөр бүр	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
7		Химийн бодистой харьцан ажилладаг ажилчдад зааварчилгаа өгөх	Төслийн хэмжээнд	-	-	-	Өдөр бүр	
	<b>Нийт зардал</b>					<b>₮ 2,000,000.00</b>		

ГАЛ ТҮЙМЭР								
1	Гал түймэр	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах	Үйлдвэрийн хэмжээнд	-	₮ 900,000.00	₮ 900,000.00	Тогтмол	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011
2	Тээврийн хэрэгслийн яндангаас оч хаях	Тээврийн хэрэгслийн янданд оч баригч суурилуулах	Төслийн хүрээнд	-	Дотоод төлөвлөлтөөр	Дотоод төлөвлөлтөөр	2023 онд	Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах шаардлага
3	Шатамхай бодисын исэлдүүлэгч бодисыг хамт хадгалах	Хор аюулыг лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгалах	Төслийн хүрээнд	-	-	-	Тогтмол	Химийн бодис тус бүрийн аюулгүйн лавлах мэдээлэл
	<b>Нийт зардал</b>					<b>₮ 900,000.00</b>		
ҮЕР УС								
1	Химийн бодис үерийн усанд норх	Химийн бодисыг усанд норхоос хамгаалж, агуулахын шалан дээр нэмэлт суурь тавих	Төслийн хүрээнд	-	₮ 1,000,000.00	₮ 1,000,000.00	2023 онд	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014
	<b>Нийт зардал</b>					<b>₮ 1,000,000.00</b>		

**ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Хөрс, ус, агаарын бохирдол. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл	Хог хаягдлын зэрэглэлийг тогтоолгох	Үйлдвэрийн хэмжээнд Төслийн хэмжээнд	-	₮ 2,000,000.00	Жилд 1 удаа	₮ 2,000,000.00	2023 онд	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар тушаал
2		Хог хаягдлын тооллого хийж, эх үүсвэр тус бүрээс үүсэх хаягдлын төрөл, тоо хэмжээг тогтоолгох						2023 онд	Хог хаягдлын тухай хууль
3		Ашигласан химийн бодисын сав баглаа боодлыг ашиглалтын дараа цуглуулж химийн бодисын нийлүүлэгчид буцаан тушаах	Төслийн хэмжээнд	тн	Үйл ажиллагааны зардлаар	тн	Үйл ажиллагааны зардлаар	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль “Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6548:2014”
4		Химийн бодисын сав баглаа, хаягдлыг их хэмжээгээр хуримтлуулж удаан хугацаагаар хадгалахгүй байх	Төслийн хэмжээнд	тн	Дотоод зардлаар	тн	Дотоод зардлаар	Тогтмол	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, устгах журам”- Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын

5		Ажилчдын хог хаягдлын хууль эрхзүйн орчин, хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах	Төслийн хэмжээнд	₮ 500,000.00	Дотоод хяналтаар	Жилд 2 удаа	Дотоод хяналтаар	Тогтмол	сайд, Эрүүл мэндийн сайдын 54/А/136/А/125 дугаар хамтарсан тушаал
	<b>Нийт зардал</b>						₮ <b>2,000,000.00</b>		



**АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
1	Хөрсний хүнд металлын үзүүлэлтээр	Үйлдвэр, агуулах орчмын хөрсний 5 цэг	Жилд нэг удаа	1	₮ 137,000.00	₮ 685,000.00	Төслийн талбайн хөрс бохирдуулагч бодисууд болон хүнд металлын хэмжээг тодорхойлох	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд,
								MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодисэлементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Ус хүнд металл, химийн үзүүлэлтээр	Ундны ус	Жилд нэг удаа	1	₮ 50,000.00	₮ 100,000.00	Төлсийн талбайд ашиглагдаж буй ундны болон хаягдал усан дахь хүнд металлын хэмжээг тодорхойлох	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.
		Хаягдал ус						MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага.
3	Агаар орчны шинжилгээ	Үйлдвэр, агуулах орчмын агаарын 5 цэг	Жилд нэг удаа	1	₮ 41,000.00	₮ 205,000.00	Төслийн талбайн агаар дахь бохирдуулагч, дуу чимээний хэмжээг тодорхойлох.	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
<b>Нийт зардал</b>						<b>₮ 768,000.00</b>		

**АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
1	Сум орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулж байгаль орчныг хамгаалах чиглэлийн ажилд хамтран ажиллах	Дотоод зардлаар	2023 онд			Салбарын дарга	Сум орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулан, байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд хамтран ажиллах
2	Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	Дотоод зардлаар	4 сар	7 сар	10 сар	Салбарын дарга	Бүх нийтийн цэвэрлэгээ тогтмол зохион байгуулж төслийн талбай орчмыг цэвэр, аюулгүй байлгах
3	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр, ажилчдын дунд сургалт семинарыг улиралд нэг удаа тогтмол зохион байгуулах	Дотоод зардлаар	1-р улирал		3-р улирал	Салбарын дарга, БО мэргэжилтэн	Байгаль орчны чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаа болон ажилчдын оролцоо, хариуцлагын талаар сургалт зохион байгуулах
4	MNS ISO 14001:2016 “Байгаль орчны менежментийн тогтолцоо – шаардлага, хэрэглэх арга зүйн заавар”, Зарчим, тогтолцоо, дэмжих аргачлалын заавар” стандартад сайжруулалт хийх	Дотоод төлөвлөлтөөр	2023 онд			Салбарын дарга, БО мэргэжилтэн	MNS ISO 14001:2016 стандартын хэрэгжилт, үүрэг хариуцлага, оролцоотой холбоотой үйл ажиллагаа
5	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Гүйцэтгэлээр	2023 онд			Салбарын дарга	Налайх дүүргийн ЗДТГ, ИТХурлаас гаргасан санал хүсэлтийг гэрээний дагуу харилцан шийдвэрлэх

6	Болзошгүй осол, гал унтраах хэрэгслээр байгууллагыг бүрэн хангах арга хэмжээ авах, гал унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Гүйцэтгэлээр	2023 онд	Салбарын дарга	Төслийн хэмжээнд ашиглагдаж буй гал унтраагуур болон иж бүрдлийг тогтмол хянан шалгаж шаардлагатай тохиолдолд шинэчлэх. Галын аюулгүй байдал болон гамшгийн бэлэн байдлын сургалт зохион байгуулах
7	Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарч болзошгүй бусад зардал	Хөрөнгө оруулалтаар	2023 онд	Салбарын дарга	Төслийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй бусал үйл ажиллагааны зардлууд
8	Компанийн үйл ажиллагаа, БО хамгаалах талаар мэдээллээр хангах /сум орон нутаг/	-	2023 онд	Салбарын дарга	Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдэж буй ажиллагааны талаар тогтмол мэдээллээр хангах
<b>Нийт зардал</b>		<b>₮</b> -			

**АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ  
НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

<b>№</b>	<b>БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах ороцлогч талууд</b>	<b>Тайлагнах хэлбэр</b>	<b>Мэдээллийн агуулга</b>	<b>Зохион байгуулах хугацааны тов</b>	<b>Тайлагнах зардал, төг</b>	<b>Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан</b>	<b>Зохион байгуулах газар</b>
1	Багийн иргэдийн хурал, нөлөөллийн бүсэд өртөгч иргэд	Хурал, танилцуулга	МЕРА ХХК-ийн үйл ажиллагаа, БО хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэж буй ажил, орон нутагтай хамтын ажиллагааны талаар	3-р улирал	₮ 500,000.00	Салбарын дарга, БО-ны мэргэжилэн нар	Налайх дүүрэг
	<b>Нийт зардал</b>				<b>₮ 500,000.00</b>		